

Аврагчийн аравны нэгийн хуулийн талаарх сургаалууд

Дараах эх сурвалжуудыг судалж, таныг болон бусдыг аравны нэгийн хуулийг дуулгавартай дагахад юу өдөөж болохыг олж мэд.

Судар:

Малахи 3:8–10; Иохан 7:17; Сургаал ба Гэрээ 119:5–7

Мэдэгдэл ба бусад эх сурвалж:

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Стивэн Ж.Ланд ийн заасан.



Өсвөр үеийнхэн аравны нэгээ бүрэн төлснөөр Тэнгэрлэг Эцэгтэй тогтвортой харилцаа тогтоодог. Тэд энэ зарлигийг дуулгавартай дагаж, аравны нэгээ төлөх тоолондоо золиослол болон харилцаа хамаарлын шинэ холбоог үүсгэж байдаг. (Стивэн Ж.Ланд, “Институт, семинар ба үр дүнгээ өгдөг бусад зүйл” [Семинар, институтийн жил тутмын сургалтын нэвтрүүлэг дээр хандаж хэлсэн үг, 2023 оны 1-р сарын 27], broadcasts.ChurchofJesusChrist.org)

Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч дээр ийн зөвлөдөг.

Бурханы зарлигуудыг сахиснаар Түүнийг хайрладгаа харуул. . . .

. . . Та мацаг барьж, аравны нэг болон өргөлүүдээ төлснөөр Бурханы ажил танд материаллаг зүйлсээс ч илүү чухал гэдгийг Түүнд харуулдаг. (Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч [2022], 11–12)

Ахлагч Стэнли Г.Эллис Далын гишүүнээр үйлчилж байхдаа ийн асуужээ.



Бидэнд орлогынхоо 90 хувийг ашиглаад, *дээрээс нь* жилийн орлогоо 100 хувь өөрсдөө ашиглан, өөрийнхөөрөө амьдрахаас *Их Эзэний тусламжтайгаар* амьдрах нь илүү дээр байх болно гэсэн аравны нэгийн талаарх [Их Эзэний] амлалтад итгэх *итгэл* байна уу? (Стэнли Г.Эллис, “Бид Түүнд итгэдэг үү? Хүнд хэцүү зүйлс тустай байдаг,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 115)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн заажээ.



Бид аравны нэгийн хуулийн тухай зааж мөн гэрчилж байхдаа үүнээс хүлээн авдаг гэнэтийн эсвэл агуу том, амархан олж харах боломжтой материаллаг адислалуудаа тодруулан ярьдаг. Иймэрхүү төрлийн адислалууд үнэхээр тохиодог. Гэхдээ энэ зарлигт дуулгавартай байснаар олж авдаг янз бүрийн адислалын зарим нь чухал хийгээд чимээгүй байдаг. . . .

Жишээ нь: Бидний хүлээн авдаг чухал, агуу адислалуудын нэг бол хүслээ хазаарлаж, байгаа зүйлдээ талархах хүчийг өгдөг сүнслэг бэлэг юм. . . .

Заримдаа биднийг Бурханаас амжилт гуйхад Тэр бидэнд бие махбодын болон оюун санааны тэсвэр хатуужлыг өгдөг. Бид хөгжил цэцэглэлтийг гуйж болох бөгөөд тод томруун хэтийн төлөв, улам их тэвчээрийг хүлээн авна. (Дэвид А.Бэднар, “Тэнгэрийн цонхнууд,” 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 19–20)

Мэри Фийлдинг Смит бол Хайрум Смитийн бэлэвсэн эхнэр, ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн ээж юм. Нэгэн хүн түүнийг аравны нэгийн хуулийг сахихад дэндүү ядуу байна гэж хэлэхэд ингэж хариулжээ.

Намайг адислал бүү аваасай гэж байгаа юм уу? . . . Аравны нэг бол Бурханы хууль. Үүнийг төлснөөр адислагдах болно гэдэгтээ итгэдэг учраас би аравны нэгийг төлдөг юм. (Mary Fielding Smith, quoted by Joseph F. Smith, in Conference Report, Apr. 1900, 48)